

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.07.23

Баянцогт

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2018 оны хагас жилийн тайлан мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүллээ.

Тайлант сард Ардын хувьсгалын 97 жилийн ойн Үндэсний их баяр наадмын үйл ажиллагааг 7-р сарын 05,06-ны өдрүүдэд зохион байгууллаа. Баяр наадмын өдрүүдэд сумын Засаг даргын Хариуцлагатай эргүүл жижүүр томилох тухай захирамж гарган Цагдаагийн албанд хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа: Сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ирсэн бичиг-27, явуулсан бичиг-11, А захирамж-6, Б захирамж-4, А тушаал-1, Б тушаал-8 гарсан байна.

СӨГ: Тайлагт сард сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ажил хүсэх тухай 1 өргөдөл хүсэлт ирсэн бөгөөд Газрын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт санал хүргүүлээд байна. Энэ сарын байдлаар санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай хугацаа болоогүй өргөдөл хүсэлт байхгүй.

Иргэний бүртгэл: Тайлант сард шинэ төрсөн-8, эцэг тогтоолт-2, Овог нэр өөрчлөлт-1, нас барсан-2, шилжиж ирсэн-7, шилжиж явсан-10 иргэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-н дагуу төрсөн 8 хүүхдэд хүндэтгэл үзүүлж Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өгсөн байна.

Хөдөлмөр, халамж: Энэ оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг 42 иргэнд 6255.0 мян/төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 34 хүнд 2305.0 мян/төгрөг, Жирэмсний тэтгэмжийг 11 эхэд 298.0 мян/ төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 75 эхэд 3737.1 мян/ төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 480.0 мян/ төгрөг, 2-р одонтой 2 эхэд 200.0 мян/ төгрөг төгрөг, Насны хишиг 4 иргэнд 200.0 мян/ төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 800000 төгрөг олголоо. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 3 эхийг тэтгэмжид хамрууллаа. МУЗГ-ын 2017 оны 12-р сарын 13-ны өдрийн 340-р тогтоолын дагуу 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн олгох 0-3 насны хүүхэдтэй 5 эхийн материалыг хүлээн авч хувийн хэрэг нээж, тэтгэмжийг олгоод байна. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 1өрхийг судалгаанд хамруулж түвшинг нь тогтоолголоо.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 7 дугаар сард 20065.2 мянган төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 12 даатгуулагчаас 538.5 мян төгрөгний орлого төвлөрүүлсэн байна. Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт - 370 хүнд-116950.8 мян төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт-116 хүнд- 29739.0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 27 хүнд 7183.0 мян төгрөг,цэргийн өндөр насны тэтгэвэр 2 хүнд-1688.2 мянган төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүн-404.5 мянган төгрөг нийт 153872.8 мян төгрөг тус тус тавьж олголоо. Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж 3 хүнд-549.6 мянган төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 5 хүнд-6474.7 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 2 хүнд-2000.0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжинд 5 хүнд 773.2 мянган төгрөгийг хуваарийн дагуу харилцагч банкуудаар дамжуулан олголоо.

Харилцагч банкаа солиулж өөрчлүүлэхээр хүсэлтээ ирүүлсэн 4 , мөн зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авахаар баримт материалаа ирүүлсэн 1 тэтгэвэр авагчийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлсэн.

ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөө аж ахуйн талаар: Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт хийх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Хонгор-Овоо 3 багийн малчин С.Шинэбаяр нь гоц халдварт шүлхий өвчний голомтоос мал зөвшөөрөлгүй тууж ирж байна гэсэн мэдээллийн дагуу тус иргэнтэй уулзаж мэдэгдэл өгч Сэлэнгэ гранд”МЭҮН-н Малын эмч Г.Сугармаатай хамтран малд нь үзлэг шинжилгээ хийсэн байна.

Швейцарийн хөгжлийн агентлаг, МБАНХ-оос хэрэгжүүлж буй “Ногоон алт- малын эрүүл мэнд” төслийн хүрээнд энэ сард Шар-Ус 1-р баг, Рашаант тосгонд 23 малчин өрхөөс бүрдсэн “Гурт” БАХ байгууллаа.

Хөрөнгө оруулалт: Энэ сард аймгийн Засаг даргын эрх шилжүүлсэн сумын Эрүүл мэндийн төвийн морг гражийн дээвэр, хаалга, цонх засварын ажил болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багийн Орон сууц хорооллын явган хүний зам тавих ажлын тендер шалгаруулалтыг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг ЗДТГ-н даргын тушаалаар томилон зохион байгууллаа. Эрүүл мэндийн төвийн морг,гражийн дээвэр, хаалга, цонх засварын ажлын гүйцэтгэгчээр “Онъ тэнгэрийн бичиг”ХХК шалгарч гэрээ байгуулаад байна. Баянцогт 2-р багийн Орон сууц хорооллын явган хүний зам тавих 27,969,900 төгрөгийн төсөвтэй ажилд нэг ч компани тендер ирүүлээгүйгээс амжилтгүй болж хуулийн 3 хүртэлж компанид үнийн санал ирүүлэх урилга хүргүүлээд байна.

2018 онд аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудаас Баянцогт 2-р багт Ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах ажил 100% хийгдэж гэрээг дүгнэн хүлээж аваад байна.

Төсөв санхүү: ЖИМСЭЭГЭЭС АВНА

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол: Тус сумын Шар-Ус 1-р баг, Рашаант тосгоны Ерөнхий боловсролын 2-р сургуулийн барилгад их засвар хийгдээгүй удсанаас шалтгаалан энэ сард их хэмжээний усархаг бороо орсоноос дээвэр гоожиж анги танхимууд руу ус орж, цахилгааны монтажид гэмтэл гарч 2018-2019 оны хичээлийн жилд сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа эхлэх боломжгүй болоод байгаа тул дээд шатны байгууллагуудад хандаад байна.

Эрүүл мэнд: 7-р п^ад^у í 24-í ий ^аа^еэ^еа^аа^ад í ^ее^о ^зс^еу^а 301, ^аì ^ао^еа^адì ^де^еí ^зс^еу^а-121, ^од^д-^ее^аí ^ну^дæ^еé^уо ^зс^еу^а-80, ^ау^де^еí ^уд^ау^ео-36, гэрийн хяналт-45, н^ее^о ^ао^оа^еа^а-19 ^ед^ну^í ^уу^н ^ае^ну^í ^ао^оа^еа^а-7, í ^ед^уí ^ао^оа^еа^а-12 байна. Нийт хэвтсэн-11 үүнээс гарсан - 12 одоо үлдэгдэл 4 хүн эмчлэгдэж байна. Сумын эмнэлэгт 1 эх төрсөн. Нярайг төрсний дараах вакцинд бүрэн хамруулж эх, хүүхдийн биеийн байдал сайн байна. Энэ сард нийт 21 хүүхдэд товлолын дагуу вакцинд хамрагдаж, 61 ^оз^оо^оа^еéí æé °í ^ад^еé^а үзэж гэрийн эргэлт хийсэн ^аа^еí ^а. ^Ае^ду^í ^ну^í ^ее ^оу^í ^ае^оа^í ^а ^өéí ^уу^д 1 ^уо ^оа^í ^да^аа^аæí ^ее^о 17 ^æд^уí ^ну^í ^уо ^оу^í ^ае^оа^í ^а ^аа^еí ^а. Умайн хүзүүний өмөн, хөхний өмөнгийн хавдар илрүүлэх шинжилгээнд энэ сард 2 эмэгтэй хамрагдсан байна.

ТЗХЭЗ-н МЭРГЭЖИЛТЭН	МЭДЭЭ БИЧСЭН:
	Д.МЭНД-АМАР
ЗДТГ-ЫН ДАРГА	ХЯНАСАН:
	Ш.ӨНӨРБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.08.23

Баянцогт

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хурдан шуурхай байдлыг хангаж ажиллалаа. Төрийн үйлчилгээ авах иргэдийн цаг хугацааг хэмнэх шуурхай байдлыг сайжруулах зорилгоор байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан ерөөний зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах ажлыг энэ сард хийж гүйцэтгэлээ.

Мөн 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган ажлын хэсэг байгуулан иргэдэд ахуйн болон бизнесийн хадлангийн газар эзэмшүүлэх ажил тайлант сард хийгдлээ.

Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа: Сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ирсэн бичиг-25, явуулсан бичиг-6, А захирамж-3, Б захирамж-1, Б тушаал-3 гарсан байна.

СӨГ: Тайлагт сард сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ажил хүсэх тухай 1 өргөдөл ирсэнийг бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Иргэний бүртгэл: Тайлант сард шинэ төрсөн-5, эцэг тогтоолт-1, шилжиж ирсэн-10, шилжиж явсан-15 иргэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-н дагуу төрсөн 5 хүүхдэд хүндэтгэл үзүүлж Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өгсөн байна.

Хөдөлмөр, халамж: Нийгмийн халамжийн сангийн халамжийн тэтгэвэрийг 42 иргэнд 49948,7 мян/төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 44 хүнд 16327,0 мян/төгрөг, жирэмсний тэтгэмжийг 24 эхэд 3384,7 мян/ төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 92 эхэд 27910,7 мян/төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 960,0 мян/ төгрөг, 1,2-р одонтой 177 эхэд 22500,0 мян/ төгрөг төгрөг, Насны хишиг 62 иргэнд 9480,0 мян/ төгрөгийг тус тус олгосон байна.

Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 6400,0 мян\төгрөг олголоо. Жирэмсэн эхийн тэтгэмжийг 24 эхэд 3384,7 мян/төг олгов. Ахмад настны хуулийн дагуу 4 ахмад настанд шүдний хөнгөлөлт 480,0 мян / төг, амралт рашаан сувилалд амарч сувилуулсан 30 ахмад настанд хөнгөлөлт замын зардалд 3453,6 мян/төгрөгийг тус тус олгож ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд шүдний хөнгөлөлт 120,0 мян / төгрөг өгөв. МУЗГ-ын 2017 оны 12-р сарын 13 ны өдрийн 340-р тогтоолын дагуу 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн олгох 0-3 насны хүүхэдтэй 92 эхийн материалыг хүлээн авч хувийн хэрэг нээж, тэтгэмжийг олгоод байна. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 14 өрхийг судалгаанд хамрууллаа.

ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөө аж ахуйн талаар: Тайлант сард ургац тогтоолтын ажил хийгдэж сумын дунджаар 1 га-аас 10цн ургац хураан авах төлөвтэй байна. 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт хийх ажлаар хөдөөгүүр ажиллаж өвчний голомттой бүсээс олон тооны мал тууварлан ирж байгаа гэсэн мэдээллийн дагуу тус сумын Баянцогт 2-р багийн иргэн Б.Батбаатар, Д.Эрдэнэбат,

Бусад ажлын талаар: Тайлант сард УИХ-н гишүүн Д.Эрдэнэбатын санаачилга, дэмжлэгтэйгээр “Малчдын бэсрэг наада” арга хэмжээг зохион байгууллаа.

МЭДЭЭ БИЧСЭН:

ТЗХЭЗ-н МЭРГЭЖИЛТЭН

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.09.25

Баянцогт

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган төр, төсвийн байгууллагуудад хүргүүллээ. Энэхүү ажлын хүрээнд Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн болон багш, эмчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалт зохион байгуулах болон ажлын цагаар ажлын байрандаа байж ажлын цагийн бүтээмжийг дээшлүүлэх, иргэд үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харьцах зэрэг болон бусад ажлууд зохион байгуулагдаж байна. Тайлант сард төр, төсвийн байгууллагуудад сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчиж сахилгын шийтгэл тооцуулсан албан хаагч байхгүй. Сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт Ажил сайжруулах талаар 14 хоногийн хугацаатай үүрэг даалгаварыг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаас үүрэг өгсөн байна.

Тайлант сард “Аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлт, 2019 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийн төсөлд тусга саналыг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүллээ. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу сумын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 2019 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулан сумын ИТХ-р хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Олон улсын Ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр сумын Ахмадын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн Ахмадын уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээг энэ сарын 26-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Сумын “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөгөөн”-нийг энэ сарын 5-ны өдөр зохион байгуулж Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн болон иргэдэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг танилцуулж санал хүсэлтийг нь сонслоо.

Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа: Сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 41 албан бичиг ирж, сумын Засаг даргын Тамгын газраас нийт 9 албан бичгийг дээд шатны байгууллагууд руу явуулсан байна. Сумын Засаг даргын ажил хэргийн чанартай захирамж-9, Засаг даргын Тамгын газрын боловсон хүчинтэй холбоотой 2 гарсан байна.

СӨГ: Тайлагт сард сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ажил хүсэх тухай 1 өргөдөл ирсэнийг бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Иргэний бүртгэл: Тайлант сард шинэ төрсөн-8, эцэг тогтоолт-1, нас баралт-1, үрчлэлт-1, овог нэр өөрчлөлт-1 хийгдсэн байна. Шилжиж ирсэн-14, шилжиж явсан-20 иргэн байна.

Хөдөлмөр, халамж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогдох Жижиг зээлийн төслүүдийг сонгон шалгаруулж ирсэн 7 төслийг Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон хэлэлцлээ. Уг ирүүлсэн төслүүд нь суманд шинэ ажлын байр бий болгох мөн тогтмол үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангахуйц гэж үзэн банк руу шилжүүлээд байна.

Энэ оны 9-р сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг-42 иргэнд-56674,0 мян/төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжийг-44- хүнд 17602,0 мян/төгрөг, Жирэмсний тэтгэмжийг-24 эхэд 3384,7 мян/төгрөг, 0-3 насны хүүхэдтэй-103 эхэд 32510,7 мян/төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 1440,0 мян/ төгрөг, 1, 2-р одонтой 179 эхэд 22700,0 мян/ төгрөг төгрөг, Насны хишиг-68 иргэнд 9780,0 мян/ төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж-7200,0 мян/төгрөг олгосон байна. Жирэмсэн эхийн тэтгэмжийг-24 эхэд 3882,0 мян/төг олгосон.

Ахмад настны хуулийн дагуу 4 ахмад настанд шүдний хөнгөлөлт 480,0 мян/төг, Амралт рашаан сувилалд амарч сувилуулсан 32 ахмад настанд хөнгөлөлт замын зардалд 3433,6 мян/төгрөгийг тус тус олгож ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн 120,0 мян/төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

МУЗГ-ын 2017 оны 12-р сарын 13-ны өдрийн 340-р тогтоолын дагуу 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн олгох 0-3 насны хүүхэдтэй 103 эхийг тэтгэмжид хамрууллаа. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 16 өрхийг судалгаанд хамруулж түвшинг нь тогтоолгосон байна.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 9 дугаар сард 32500.0 мянган төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 20 даатгуулагчаас 860.0 мянган төгрөгний орлого төвлөрүүлсэн байна.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт- 370 хүнд-115879.7 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 125- хүнд-31953.2 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 28 хүнд 7457.3 мянган төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэр 3 хүнд-2102.1, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүн-404.5 мянган төгрөг нийт 157796.8 мян төгрөг тус тус тавьж олголоо.

Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж 3 хүнд-345.6 мянган төгрөг жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 хүнд-844.4 мянган төгрөг, харилцагч банкуудаар дамжуулан олголоо.

ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөө аж ахуйн талаар: Аймгийн Засаг даргын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 10 тоот албан даалгаварын дагуу малчид, мал бүхий иргэдийн 2018-2019 оны мал өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, өвс хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороогоо засварлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэн ажиллаж одоогийн байдлаар 700тн байгалийн хадлан, 1тн гар тэжээл бэлтгээд байна. Сумын аюулгүйн нөөцөд 50тн өвс, 30тн тэжээл бэлтгэхээр аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж ажиллаж байна.

Мал аж ахуй: 2018 оны түүвэр тооллогоор тэмээ-559, адуу-14803, үхэр-20614толгой, хонь-121803 толгой, ямаа-94389 толгой мал тоологдох тооцоо гарч үүнээс 2018-2019 оны өвөл, хаврын улиралд хонин толгойд шилжүүлсэнээр 432,607 толгой малд 1600мян\тн өвс, 3000 мян\тн хүчид тэжээл шаардагдах тооцоо гарч байна. Энэ 9-р сарын байдлаар өссөн дүнгээр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Шүлхий өвчний вакцин-16518 үхэрт, шөвөг яр-24300 толгой төлд, томуу-1500 адуу, сахуу-1500 унага, дуут-8400 үхэрт, боом-14763, бод-12783 толгой бог малд, галзуу -360 нохойд тус тус хийгдсэн байна. Мөн празиттах өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 31000 бог, 9200 бод, угаалга 25000 богд хийгээд байна. Бруцеллёзийн вакцин тугал-1103 толгой, хурга-17461 толгой, ишиг-8311 толгойд хийгдээд байна.

Газар тариалан: Ургац хураалтын ажилтай танилцаж авах арга хэмжээний талаар аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж байгаа ба 9-р сарын 25-ны байдлаар ургац хураалт 20%-тай явагдаж байна. Нийт 13631.81 га үүнээс улаан буудай-10831га , овьёос-20га, рапс-2671га , төмс 7.84га-аас 78.4 тн ургацыг хурааж, хүнсний ногоо 48.97га-аас 391.76тн-ыг хураан аваад байна.

Сумын баялаг бүтээгчдийг сурталчлах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Орхонтуул суманд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг 09.26-ны өдөр зохион байгуулагдана.

Байгаль орчны чиглэлээр: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2018 оны 01-р сарын 04-ний өдрийн 18-04-001/02 тоот байнгын удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж Баянцогт 2-р багийн нутаг Нүхэн орчимд хууль бусаар зохих зөвшөөрөлгүй мод түлээ бэлтгэсэн 3 иргэний зөрчлийг илрүүлж сумын хэсгийн төлөөлөгчид шилжүүлэн эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулж байна. Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтуудыг ой бүхий газруудад хийж, ой хаасан хугацаанд ойн дагалт баялаг ашиглахгүй байх ой хээрт аялал зугаалга хийхгүй байх талаар анхааруулга санамж бичиг тарааж ухуулга сурталчилгаа хийсэн байна.

Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус сумын Шар-Ус 1-р баг Рашаант тосгоны нутаг Цагаан хөтөл, Булын түнтгэр, Ажинт, Баянцогт 2-р багийн нутаг Давхарын ар, Хоньч, Үнэгтэй зэрэг газраар зусаж, намаржиж буй малчин иргэдийн дунд гарсан хилийн цэсийн маргаан, бэлчээр ашиглалт, өвөлжөө, хадлангийн талбайн маргааныг шийдвэрлэж гарсан зөрчлийг таслан зогсоох зорилгоор ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга, Татварын байцаагч, Газрын даамал, Байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтын ажил зохион байгуулж гарсан зөрчил дутагдал, хилийн цэсийн маргааныг газар дээр нь арилгаж, Байгаль орчны багц хууль болох Газрын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Зөрчлийн тухай хуулиудаар хуулийн сургалт сурталчилгаа хийсэн байна. Сумын ЗДТГ-ын даргаар ахлуулсан хяналт шалгалтын ажлын хэсэг Шар-Ус 1-р баг, Баянцогт 2-р багийн нутагт өөр аймаг сумдаас отор нүүдэл хийж яваа малчин өрхүүдэд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны А/128 тоот “Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” захирамж, Сумын Засаг даргын 2018 оны А/79 тоот “Бэлчээр чөлөөлүүлэх тухай” захирамжийн хэрэгжилтийг хангуулан байсан хугацааны бэлчээр ус ашигласны төлбөр тооцоог барагдуулан хугацаатай албан шаардлага өгч албадан нүүлгэх талаар арга ажил зохион байгуулж ажилласан байна. Үүнд: Сэлэнгэ аймаг Орхон сумын 5 малчин өрх, Завхан аймгийн Дөрвөлжин сумын 2 малчин өрх, Увс аймгийн Тэс сумын 2 малчин өрх тус тус ирсэн байсныг албадан нүүлгэх талаар хугацаатай мэдэгдэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Хог хаягдлын стандартыг хангуулах зорилгоор төвлөрсөн 2 хогийн цэг орчмын гадуур асгарсан хог хаягдлыг түрж тэгшлэх арилгаж цэвэрлэх талаар багийн Засаг дарга нар болон байгаль хамгаалагч нарт үүрэг даалгавар өгч хяналт тавин ажиллалаа. Мөн малчин өрхүүдэд хогоо ангилан ялгаж хаях, тагтай саванд хийж сумын болон багийн төвүүдийн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хаяж булж устгаж байх талаар зөвлөмж өгсөн байна.

Амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Туул болон Орхон голын сав газраар Цагдаагийн албатай хамтран эргүүл хяналт шалгалтуудыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар ямар нэгэн зөрчил илэрээгүй байна.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгжүүд болон хууль бусаар нөхөн сэргээлт нэрийн дор олборлолт явуулж байгаа байдалд Аймгийн МХГ-ын даргын баталсан 2018 оны 18-04-001/02 тоот удирдамжийн дагуу аймгийн МХГ-ын нэгдсэн шалгалтын хүрээнд ГУУХУБайцаагч, Хөдөлмөр хамгаалалын хяналтын улсын байцаагч нартай хамтран хяналт шалгалтуудыг хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтыг 3 аж ахуйн нэгж болон 1 иргэнийг хамруулан зохион байгууллаа. Үүнд тусгай зөвшөөрөл бүхий Флинкмонголиа, Бийд майнинг, Адекс майн ХХК-уудын өнгөрсөн оны үйл ажиллагаа нөхөн сэргээлтийн байдал, энэ оны баримт бичгүүдийн байдалд хяналт шалгалтуудыг хийсэн байна.

Сумын Засаг даргын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ахуйн болон Бизнесийн чиглэлээр хадлан бэлтгэж байгаа иргэн аж ахуйн нэгжийн хадлан бэлтгэл, газрын ашиглалт хамгаалалт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдалд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтад 22 иргэн, 6 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагагаас зарласан жилийн хүрээнд хяналт шалгалтад хамрагдсан иргэн аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөвлөн туслах чиглэлээр хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж байна. Хяналт шалгалтад хамрагдсан иргэд аж ахуйн нэгж байгууллагад Газрын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Зөрчлийн тухай хуулиудаар хуулийн сургалт сурталчилгаа хийж гарын авлаг боршуур тарааж давхардсан тоогоор 8 аж ахуй нэгж байгууллага, 94 иргэнийг хамруулсан байна.

Намрын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үнс нурмаа тагтай саванд хийх, ой хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн сургалт сурталчилгаа хийж зөвлөмж гарын авлаг тараан гал гаргахгүй байх талаар гарын үсэг зуруулан баталгаа гаргуулан ажилласан байна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

“Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгаа” сумын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулж түүнийг хэрэгжүүлэх журмыг батлууллаа. “Угийн бичиг хөтлөх” олон нийтийн санаачлагыг өрнүүлэх зорилгоор 9.26-нд үзэсгэлэн гаргахаар бэлтгэл ажил хангагдан ажиллаж байна.

Аймгийн ГБХЗХГ-т эрсдэлтэй хүүхдийн судалгааг 50 айл өрхөөс авч нэгтгэн хүргүүллээ.

Боловсрол:

СӨБ: Сумын 24-р цэцэрлэгээс “Хүүхдийн төлөө хамтдаа” чуулганыг 09 дүгээр сарын 21-ний өдөр сумын Соёлын төвд цэцэрлэгийн эцэг, эхчүүд сумын удирдлага, багш ажилтанг оролцуулан амжилттай зохион байгуулан явуулсан. Чуулганаар Гэр бүл хүүхэд хамгаалал, цахим орчны аюулгүй байдал, Хоол үйлдвэрлэл үйлчилгээ, сургалтын орчны MNS6558:2015 стандартын талаар сургалт болон хэлэлцүүлэг мэдээлэл өгөх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажилласан.

Хоол үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг явуулах, эрүүл таатай орчин бүрдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор засвар үйлчилгээг хийж мөн цэцэрлэгийн хүлээн авах болон коридорыг оохордох, будах, сургалтын байгууллагын орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийн сурч хөгжих эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллах, сургалтын орчинг сайжруулах MNS6558:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэгийн дээвэр засварлах, гадна дотно хаалга шинэчлэх, 2 ангийн шалыг паркетлах, болон бусад урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэнээр байгууллагын дулаан алдах эрсдэл багасаж чадсан байна.

Цэцэрлэгийн анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх анги дүүргэлтийг стандартаас хэтрүүлэхгүй байх үүднээс нэг ангийг шинээр нээж нийт бүлэгт 25 -с ихгүй хүүхэд авхаар зохион байгуулан ажиллаж байна. Цэцэрлэгт элсэх насны хүүхдийн статистик мэдээг маягтаар гаргаж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах нөхцөл боломжоор ханган ажиллаж 6 бүлэгт 140 хүүхэд хамруулан ажиллаж байна.

Багш ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх зорилгоор энэ хичээлийн жилд 4 багшийг магистрийн сургалтанд, 1 багшийн бакалаврийн сургалтанд хамруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Боловсролын мэдээллийн системийн 3 өдрийн

сургалтанд Арга зүйчийг хамрууллаа. Байгууллага дээр ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Ажилд орохыг хүссэн өргөдөл 2 ирж бүртгэлд бүртгэн ажиллаж байна.

Ерөнхий боловсрол: 2018 -2019 хичээлийн жилд ЕБ1,2-р сургуульд нийт 567 хүүхэд суралцаж байна. Шинэ хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн зорилго зорилтоо тодорхойлох санал хүсэлтийг багш, суралцагч, эцэг эхчүүдээс авч нэгтгэн 09-р сард багш нарын зөвлөгөөний хурлаа хийж зорилго, зорилтоо тодорхойлж, дотоод бүтэц зохион байгуулалт болон хөдөлмөрийн дотоод журмаа хэлэлцэн баталсан. Мөн сургалт, соёл, хүмүүжлийн ажлын төлөвлөгөө, график гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Боловсролын байгууллагын менежментийн мэдээллийн систем”-шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн БСУГ-аас сургалтын менежерүүдийн дунд сургалтыг зохион байгуулсан. Тухайн системд багш, суралцагчдын мэдээллийг оруулж дуусаад байна.

Цахим орчинд хүүхэд багачуудыг аюулгүй байдалд байлгах гэмт хэрэг өртөхөөс сэргийлэх “UNFRIEND”сэдэвт сургалтыг 8-11р ангийн суралцагчдад зохион байгууллаа нийт 4 ангийн 74 суралцагч хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 258 тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Багш, ажилчдын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дээрээ архи согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтыг тусгаж өгсөн.
- Багш, ажилчдын ажлын цаг ашиглалтын дэвтэр гарган бүртгэн сарын эцэст дүгнэж байна.
- Багш нарын зөвлөгөөний хурлаар ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж эхлээд байна.

Эрүүл мэнд: Нийт 443 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг-76, амбулаторийн үзлэг-182, идэвхтэй хяналтаар-37, гэрийн эргэлт-97, дуудлага-51 үүнээс алсын дуудлага 25 байна. Жирэмсний хяналтанд 10 эх хянагдаж байна. Шинээр 3 эх хяналтанд орсон. Артерийн гипертензи,чихрийн шижин илрүүлэх шинжилгээнд 40-65 насны 84 хүнийг хамруулсан, мөн элэгний хавдар эрт илрүүлэх шинжилгээнд 76 хүнийг тус тус хамруулаад байна. 0- 5 насны 102 хүүхдийг жинлэн 6 сартайгаас 2 настай 6 хүүхдэд ОНБТБ уулгасан. Эмнэлгийн ажилчдад ёс зүйн чиглэлээр чанарын багаас сургалт 1 удаа хийсэн. “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаалын хавсралтаар батлагдсан загварыг ашиглан өөрийн байгууллагын онцлогт тохируулан асуумжийг боловсруулан 10 хэвтэн эмчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан ба эмнэлгийн ажилчдын зан харьцаа ёс зүйтэй холбоотой санал шүүмжлэл ирээгүй. 2018 оны эхний 9 сарын байдлаар сахилга хариуцлага, ёс зүйн зөрчил гарган арга хэмжээ тооцуулсан албан хаагч байхгүй, сумын Засаг даргын 2018 оны А/71 тоот захирамжийн дагуу ёс зүйн зөрчилгүй хамт олон болох зорилт тавин ажиллаж байна.

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын 8 төсөвт байгууллагуудын 2018 оны хагас жилийн тайланг гаргаж баталгаажуулсан ба сумын нэгтгэсэн тайланг гаргаж, баталгаажууллаа. Төсвийн гүйцэтгэлийн 2018 оны 08 сарын мэдээг маягтын дагуу авч нэгтгэсэн ба 2018 оны хагас жилийн Санхүүгийн тайланг гаргаснаар өглөг, авлага үүссэн шалтгааныг тодруулж, барагдуулах ажил хийгдэж, жилийн эцэст өглөг, авлагагүй байх арга хэмжээ авч ажиллаж байна. Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг гаргаж сумын төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайланг хугацаанд нь аймгийн Аудитын газарт хүргүүлээ. Энэ сарын 14-

нд Сайхан суманд явагдсан Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс зохион явуулсан холбогдох хуулийн сургалтанд суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Үрдүн”ББН, “Замбал зоог”, “Сэлэнгэ сүрэг”ХХК, “Туулын хишиг”ОНӨААТҮГ, “Хөх сондор”ХХК зэрэг аж ахуй нэгжүүдийг хамрууллаа.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ЭМТөвөөс бусад байгууллага 2018 оны хагас жилийн санхүүгийн тайланг оруулаагүй байна.

Мөн энэ сарын 20-нд Аймгийн Аудитын газраас ирсэн төлөвлөгөөт шалгалтанд төр, төсвийн 8, “Туулын хишиг” ОНӨААТҮГ газрыг хамруулан 2017 оны санхүүгийн баримтыг шалгуулсан. Байгууллагын дарга, эрхлэгч нар Соёлын төв, Рашаант ЭМТөв салбарын эрхлэгч, 1,2-р сургуулийн сургалтын менежер нарт холбогдох хууль, журмын талаар тайлбар яриа хийн, санал хүсэлтийг сонсох ажлыг зохион байгууллаа.

Орлого бүрдүүлэлт: Улсын төсөвт 9-р сарын 20-ны байдлаар 15980.0 төлөвлөгөөнөөс 10570.5 оруулж 68.6%-тай биелсэн, Аймгийн төлөвлөгөө 100775.0 байснаас 73844.7 оруулж 73.3%-тай байна. Сумын орлогын төлөвлөгөө ба биелэлтийг Татварын нэр төрлөөр харуулбал:

д/д	Татварын төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	7352.2	4696.0	63.9
2	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	-	6040.3	
3	Ургамал ашигласны төлбөр	4375.0	12380.5	282.9
4	Ан амьтны нөөц ашигласн	606.8	0	0
5	Хөрөнгө борлуулсны орлого	749.7	1680.0	224
6	Улсын тэмдэгтийн хураамж	3305.4	1605.1	48.6
7	Усны нөөц ашигласны төлбөр	1285.7	0	0
8	Татварын бус хүү, торгуулийн орлого			
9	Нэр заагдаагүй бусад орлого	40542.8	13256.9	32.7
10	Галт зэвсгийн албан татвар	1237.5	900.0	72.7
Дүн		59505.1	40558.8	68.2

Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулдаг 104 ААН, 20 гаруй иргэн байдаг байсан бөгөөд 9 сарын байдлаар 5 аан, 5 иргэн нэмэгдсэнээр 109 ААН, 25 иргэн болж татвар төлөгчийн бааз нэмэгдсэн байна.

Хөрөнгө оруулалт: Энэ онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудаас 24-р цэцэрлэгийн дээвэр, хаалга засвар, Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах ажлууд хийгдэж дууссан. Сумын ОНХсангийн хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багийн орон сууц хороололд явган хүний зам тавих ажил, аймгийн Засаг даргын эрх шилжүүлсэн Эрүүл мэндийн төвийн морг, гражийн дээвэр, хаалга, цонх засварын ажил хийгдэж улсын комисст хүлээлгэж өгөхөд бэлэн болсон байна.

Бусад ажлын талаар:

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.Мал аж ахуйн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх цех, жижиг үйлдвэр байгуулах асуудлыг бодлогоор дэмжих зорилтын хүрээнд манай суманд Сүү боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах талаар санал гаргасны дагуу зохих дэмжлэгийг үзүүлсэнээр тоног төхөөрөмжөө авчран угсарч үйл ажиллагаагаа эхлээд байна.

Суманд ашигт малтмалын хайгуулын чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй “Адекс майн”ХХК-тай тохиролцсоны дагуу 2016 онд эхлээд дутуу орхигдсон байсан хийдийн барилгыг гүйцээж ашиглалтанд оруулахаар засварын ажлыг эхлүүлсэн байна.

МЭДЭЭ БИЧСЭН:

ТЗХЭЗ-н МЭРГЭЖИЛТЭН

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.10.25

Баянцогт

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг сумын ИТХ-н хурлын ажлын албанд хүргүүлсэн байна. Сумын ИТХ-н 10-р сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явцыг хэлэлцэж хангалттай гэж үзэн 2019 оны үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн баталсан байна.

Тайлант хугацаанд аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын байдлаар гарган аймгийн Засаг даргын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүллээ.

Хууль сурталчлах, алслагдсан малчин өрхийн гишүүдэд цаг үеийн мэдээлэл хүргэх зорилготой “Явуулын иргэний танхим” арга хэмжээг Хонгор-Овоо 3-р багийн нутаг Өвөр булагт зохион байгуулж нийт 40 орчиж малчин өрхийн төлөөллийг хамруулан сургалт мэдээллийн ажил явуулж сумын Эрүүл мэндийн төвөөс зөөврийн эхо аппаратаар үзлэг оношлогоо хийж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Олон улсын Ахмадын баярын өдрийг “Хаан аав, Хатан ээжүүдээ өргөмжилье” уриан дор хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгууллаа.

Цэргийн жинхэнэ албаны 2018 оны хоёрдугаар ээлжийн татлагын ажлыг зохион байгуулан хоёрдугаар зэргийг бэлтгэл үүрэгтан залуучуудыг сум дундын эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулсанаас 9 залуу тэнцэж цэргийн албанд мордсон байна.

Аймгийн Онцгой байдлын газраас “Бэлэн байдлын үзлэг, шалгалт зохион байгуулж зарлан мэдээллийн дуут дохиог 2 удаа дуугаргаж Сумын Онцгой комисс, Штаб, Мэргэжлийн анги, Сайн дурын бүлгүүд цугларч сумын Соёлын төвд Мэргэжлийн анги сайн дурын бүлгийн үйл ажиллагаа сэдвээр сургалтанд хамрууллаа. Мөн Ерөнхий боловсролын 5,6,7-р ангид газар хөдлөлтийн болон аянга цахилгааны гамшгийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах дадал мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.

Сумын албан ёсны Orkhontuul.se.gov.mn сайт хөгжүүлэлтийг тухай бүр хийж тайлант хугацаанд 4 удаа мэдээ оруулж сайтын хандалт 251318 болсон байна.

СӨГ: Тайлагт сард сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт иргэдээс нийт 6 өргөдөл хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс түлээ нүүрсний тусламж хүссэн-1, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх 1, төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой-1, хүнсний ногооны газартай холбоотой-1, өвөлжөө бэлчээрийн газрын маргаантай холбоотой-1, тариалангийн газар эзэмших тухай-1 ирүүлсэнээс сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж хариуг холбогдох утсаар нь болон албан тоотоор өгч ажиллалаан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100%-тай хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Иргэний бүртгэл: Тайлант сард шинэ төрөлт-1, нас баралт-5, гэрлэлт-1 бүртгэгдсэн байна. Шилжиж ирсэн-9, шилжиж явсан-16 иргэн байна.

Хөдөлмөр, халамж:

“Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2018” судалгааг сумын хэмжээнд 1032 өрхөөс авч аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг авч хүргүүллээ.

Энэ оны 10-р сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг 45 иргэнд 62387,5 мян/төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 44 хүнд-19926,7 мян/төгрөг, Жирэмсний тэтгэмжийг 24 эхэд 4225,9 мян/төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 103 эхэд 36363,2 мян/төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 1440,0 мян/төгрөг, 1,2-р одонтой 179 эхэд 22700,0 мян/төгрөг төгрөг, Насны хишиг 68 иргэнд 9780,0 мян/төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 8000,0 мян/төгрөг олголоо.

Ахмад настны хуулийн дагуу 4 ахмад настанд шүдний хөнгөлөлт 480,0 мян /төг, амралт, рашаан сувилалд амарч сувилуулсан 32 ахмад настанд хөнгөлөлт замын зардалд 3433,6 мян/төгрөгийг тус тус олгож ажиллалаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд шүдний хөнгөлөлт 120,0 мян/төгрөг олгосон байна.

МУЗГ-ын 2017 оны 12-р сарын 13 ны өдрийн 340-р тогтоолын дагуу 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн олгох 0-3 насны хүүхэдтэй 106 эхийн тэтгэмжийг олгоод байна. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 16 өрхийг судалгаанд хамруулж түвшинг нь тогтоолголоо.

ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөө аж ахуйн талаар:

Сумын хэмжээнд энэ онд нийт малчин болон мал бүхий 730 өрхийн 184668 толгой мал өвөлжихөөр байна. Үүнээс Тэмээ-397 толгой, адуу- 13048толгой, үхэр-16964 толгой, хонь-88234 толгой, ямаа-66025 толгой байна. Үүнийг баг тус бүрт хуваахад Шар-ус 1-р багт 319 өрхийн 66764 толгой мал, Баянцогт 2-р багт 235 өрхийн 64103 толгой мал, Хонгор овоо 3-р баг 176 өрхийн 53801 толгой мал өвөлжинө.

Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 95522 толгой мал хамруулахаас 84418 толгой мал, боловсруулалтанд бод-4200 толгой, бог- 35300 толгойг хамруулсан байна. Туулгалтанд нохой-70, бог-87000 толгой, бод-16650 толгойг хамрагдсан. Угаалга, туулгалт, боловсруулалтанд нийт малын 71% нь хамрагдсан байна.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа гурван Мал эмнэлэг нь нийт 23700 толгой бог малыг шүрших аргаар, мөн ваннанд 8147 толгой бог малыг угаасан байна. Мөн өвөлжөө-1300мм², хаваржаа-1000мм², намаржаа-580мм², уст цэг-500мм² талбайд тус тус ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.

Хадлан тэжээл: Сумын хэмжээнд бизнесийн болоод ахуйн зориулалтаар 6700 га-д гэрээ хийгдсэн байна. Үүнээс малчин болоод мал бүхий иргэд 700га-д гэрээ хийж 9600 тонн өвс бэлтгэн аваад байна. Бизнесийн зориулалтаар 6000 га-д гэрээ хийж орон нутагт өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор бизнесийн зориулалтаар хадлан эрхэлж буй иргэдтэй гэрээ хийж сумын Аюулгүйн нөөцөд 15,0 сая төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Мөн малчин болоод мал бүхий иргэд өөрсдийн нөөц бололцоон дээр тулгуурлан хужир-117 тн, хүчит тэжээл-10тн-ийг бэлтгэн аваад байна.

Ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын орлогчийн 2018.09.28-ны өдрийн 1\712 тоот албан бичгийн хүрээнд Сумын ургацын комисс томилох тухай сумын Засаг даргын захирамж гарган ургац хураалт дуусах хүртэл мал сүргийг тариан талбайгаас хамгаалах мэдэгдэл хүргүүлэх ажлыг зохион байгуулж тайлан мэдээг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт энэ сарын 19-нд хүргүүлсэн.

Сумын Аюулгүйн нөөц бүрдүүлэлтийн мэдээг 7 хоногийн Баасан гараг бүр аймгийн Мэргэжлийн хяналтын газарт, ургац хураалтын мэдээг өдөр бүр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт өгч ажиллалаа.

Бизнесийн зориулалтаар хадлангаар гэрээ хийсэн 39 АА-нэгж, иргэдэд хяналт шалгалт хийхэд 5 иргэн хадах ёстой талбай хэмжээнээс илүү хадсан байсныг хэмжилт хийж хадлангийн салааг зогсоож буулгасан байна.

Байгаль орчны чиглэлээр: “Эх дэлхийгээ хамтдаа хайрлая” уриан дор 9-р сарын 14-ний өдөр бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Их цэвэрлэгээний ажилд албан байгууллага, аж ахуйн нэгжүүд идэвхтэй сайн оролцож нийтийн эзэмшлийн талбайд цэвэрлэгээ хийлээ. Үүнд: Албан байгууллага, аж ахуйн нэгж 16, ажилласан хүний тоо 147, цэвэрлэсэн талбай 32 га, цэвэрлэсэн хогны хэмжээ 4 тн, зарцуулсан түлшний хэмжээ 20 л байна. Энэхүү ажлын хүрээнд Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 5,6,10,11-р ангийн сурагчид өөрсдийн сумын төвийн хойд талд байрлах Майхант уул, Суварганы орчим, Туул голын эрэг дагуу газруудаар нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэн түүж шатаах, булж устган ажилласан байна. Энэхүү ажилд 10,11-р ангийн сурагчид идэвхи санаачлагатай ажилласан байна.

Намрын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үнс нурмаа тагтай саванд хийх, Ой хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн сургалт сурталчилгаа хийж зөвлөмж гарын авлага тараан гал гаргахгүй байх талаар гарын үсэг зуруулан баталгаа гаргуулан ажилласан байна. Энэхүү ажлын хүрээнд 4 удаагийн хамтарсан хяналт шалгалтаар нийт 145 иргэн, 14 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан ухуулга сурталчилгаа галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга санамж бичиг гарган тараасан.

Хог хаягдлын менежментийг зохион байгуулах чиглэлээр нэгдсэн 2 хогийн цэгийн байршлыг солих зорилгоор сумын ИТХ-аар газрын асуудлыг шийдвэрлүүлэн 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр тусгуулан газрын солбицлыг тогтоон шинээр цэг байгуулах ажлыг эхлүүлээд байна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол:

СӨБ: Багшийн ур чадвар, заах арга зүйн туршлагаа бусад багш нарт түгээн дэлгэрүүлэх зорилгын хүрээнд 2018.10.25-нд Заах ур чадварын нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг бүлгийн багш нар амжилттай заалаа. Мөн “Аав ээжтэйгээ хамтдаа уншъя” сэдэвт уралдаант тэмцээнийг бэлтгэл бүлгийн эцэг, эхийн дунд зохион байгуулж О.Оюунцэцэг 1-р байр, М.Энхжин 2-р байрыг тус тус эзэллээ. Мөн 2018.10.17-нд “Боловсролын салбарын мэдээллийн систем”-д цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг бүрэн оруулж илгээсэн.

“Дэгдээхэй” бага бүлгийн эцэг эхийн санаачлагаар багш нарын баярыг угтсан “Гар бөмбөгийн тэмцээн”-ийг эцэг эхийн дунд амжилттай зохион байгуулагдаж Ахлах бүлэг 3-р байр хүрэл медаль, Рашаантын Дунд бүлэг 2-р байр Мөнгөн медаль, Д.Туяа багштай бага бүлгийн эцэг эхчүүд 1-р байр алтан медаль, шилжин явах цомын эзэн болж ирэх жил дахин Дэгдээхэй бүлгийн нэрэмжит “Гар бөмбөгийн тэмцээн”-ийг дахин зохион байгуулахаар төлөвлөөд байна.

ТЭХЭЗ-н МЭРГЭЖИЛТЭН

ЗДТГ-ЫН ДАРГА

МЭДЭЭ БИЧСЭН:

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

Ш.ӨНӨРБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.11.23

Баянцогт

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн жинхэнэ албан хаагчдийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгалтанд 13 албан хаагч хамрагдаж хангалттай үнэлгээ авлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, 2018 оны 258 дугаар албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга ирэх оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчдаар тус хуулийг судлуулах, сурталчлах ажлыг тайлан хугацаанд зохион байгуулж сумын ЗДТГ, Рашаант тосгоны Захирагчийн ажлын алба, 1,2-р сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүд, Цаг уур зэрэг байгууллагын 120 гаруй ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамрууллаа.

Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах журмын төсөлтэй танилцан саналаа хүргүүллээ. Сумын ЗДТГ, Рашаант тосгоны Захирагчийн ажлын албаны бүтэц орон тооны судалгааг гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ.

Тайлант сард Монгол Улсын их, дээд сургуульд сургалтын төрийн сангийн зээлээр сурч төгссөн төрийн албан хаагчдын судалгааг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүллээ.

Төрийн албаны удирдах ажилтнуудын улсын Зөвлөгөөнөөс гарсан Зөвлөмж, Андгайг нийт төрийн албан хаагчдад танилцуулан байгууллага, ажилтан бүр АЗ хэмжээтэй хэвлэж нийтэд ил харагдахуйц газар байрлуулан дагаж мөрдөн ажиллаж байна.

Ирэх оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг төрийн албан хаагчдад сурталчлах зорилгоор Төрийн албан хаагчийн баримтлах зарчим, төрийн албаны удирдах ажилтнуудын улсын зөвлөгөөнөөс гарсан Андгай, Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг 60x60, 60x100 хэмжээтэй 3 ширхэг самбар захиалан хийлгэж байгууллагын үүдэнд байрлууллаа.

Бичиг хэрэг: Энэ сард сумын Засаг даргын ажил хэргийн чанартай захирамж-2, Тамгын газрын даргын ажил хэргийн чанартай тушаал-2 гарсан байна. Тамгын газраас явуулсан бичиг-26, ирсэн бичиг-37 үүнээс хариутай-15 байна.

СӨГ: Тайлант сард иргэдээс сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт нийт 2 өргөдөл ирүүлсэн байна. Үүнээс гэр хүссэн-1, түлээ нүүрсний тусламж хүссэн-1 байна. Өргөдлүүдийг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж хариуг албан тоотоор хүргүүллээ.

Иргэний бүртгэл: Тайлант сард шинэ төрөлт-5, эцэг тогтоолт-3, нас баралт-1, гэрлэлт-1 бүртгэгдсэн байна. Шилжиж ирсэн-5, шилжиж явсан-3 иргэн байна.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд “Шинэ төрсөн эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган 5 эх, хүүхдэд Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өглөө.

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол:

СӨБ: 24-р цэцэрлэгийн 2018 оны 11 дүгээр сарын хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт урьдчилсан байдлаар 80%-тай байна. Энэ сард бага насны хүүхдийн дунд ханиад их гарч өвчлөл өмнөх сараас их байна. 2018-2019 оны хичээлийн жилд Хүүхэд хөгжүүлэх сургалтын хуваарь, өдрийн дэглэм, сэдэвчилсэн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр шинэчлэх, ЗАН-ын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЕБС: ЕБ2-р сургууль нь 11 сарын 13-нд 2018-2019 оны хичээлийн жилийн “Багшийн хөгжил” сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ багш нарын илтгэлийн удалдаан зохион байгуулагдлаа. Илтгэлийн уралдаан 20 багш 10 баг оролцож 1-р байранд Технологийн багш Д.Энхмэнд, газар зүйн багш Ц.Болормаа, 2-р байранд Монгол хэлний багш Г.Нарантуяа гадаад хэлний багш М.Мөнхтуул, 3-р байранд Бага ангийн багш Д.Хишигжаргал хөгжмийн багш Ш.Тэгшжаргал байр тус тус эзэллээ.

ЕБ1-р сургууль нь энэ сард сургалтын үйл ажиллагаагаар суралцагчдын 1-р улирлын дүнг гарган сургуулийн сурлагын нэгдсэн дундаж үзүүлэлт гаргасан. Багш нарын ажлыг сар бүрээр дүгнэдэг болсонтой холбогдуулан сурагчдын гарааны ТТШ-аар багш нарын гарааны үнэлгээг тогтоож дараагийн улиралд тухайн гарааны түвшингөөсөө ахисан эсэхэд дүгнэлт гарган багшийн ажлыг үнэлж дүгнэж байна. Сурагчдын дүнг сурагч нэг бүрийн дүнгийн хуудсанд тавьж эцэг эхэд нь танилцуулан гарын үсэг зуруулсан. Сургалтын үйл ажиллагаагаараа хүүхэд бүрийг хөгжүүлэхэд шат алгасахгүй сургахад анхаарч, хүүхдийг оношилох, багш нар хамтарч хичээлээ бэлдэх заах үйл ажиллагааг эхэлж байна.

Багш нарын дунд “**Багшийн хөгжилд-сурах бичиг-сургалтын хэрэглэгдэхүүн**”-сэдэвт илтгэлийн уралдааны 1-р шатыг сургууль дээрээ зохион байгуулж 2-р шат бүсийн хэмжээнд зохион байгуулагдах тул 1-р шатанд шалгарсан баг бэлтгэл ажлаа хангаж байна.

Бусад ажлын талаар: Тайлант сард сумн төв болон Рашаант тосгоны төвд золбин нохой устгалын ажил зохион байгууллаа.

ТЗХЭЗ-н МЭРГЭЖИЛТЭН

ЗДТГ-ЫН ДАРГА

МЭДЭЭ БИЧСЭН:

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

Ш.ӨНӨРБАЯР